



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/002-НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр
	Утас: 7036-3047 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗЗА	Авто зам засвар ашиглалт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ АЗЗА” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.БАТБОЛД
ТАНАА

2025.03.14 № СЗА-2025/002/НА-СТА-ТӨВИ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь тайлант онд 2,662,523.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,611,564.2 мянган төгрөгийн зардал гарган 50,959.0 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу харьцуулалтын аргаар тендер зохион байгуулж, Бэлхи илч ХХК-иас 71,505.8 мянган төгрөгийн асфальтны индүү худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь хийж гүйцэтгэх ажил, үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнд тусгагдаагүй 570,303.3 мянган төгрөгийн өртөг бүхий гэрээт ажлыг гүйцэтгэсний улмаас орлогын төлөвлөгөөг 10.5 хувиар давуулан биелүүлж, зарлагыг 230,794.9 мянган төгрөг буюу 9.7 хувиар хэтрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	9
3.2 БАЙГУУЛЛАГЫН ГАДААД, ДОТООД ОРЧИН	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ.....	11
3.6 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	12
4. Аудитын тайлан	13
4.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	13
4.2. Материаллаг байдал	13
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	14
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ.....	15
5. Аудитын илрүүлэлт.....	15
5.1 Залруулга	15
5.2 Төлбөрийн АКТ	15
5.3 Албан шаардлага.....	15
5.4 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	874,138,377.32	953,811,348.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	384,177,759.91	194,496,675.60
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	217,659.04	0
31110	Төгрөг	217,659.04	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	383,960,100.87	194,496,675.60
31210	Төгрөг	383,960,100.87	194,496,675.60
31213	Арилжааны банк дахь харилцах	383,960,100.87	194,496,675.60
33	АВЛАГА	250,866,760.67	508,317,869.67
33401	Дансны авлага /ТӨҮГ/	250,866,760.67	508,317,869.67
35	БАРАА МАТЕРИАЛ	239,093,856.74	250,996,803.11
35300	Бэлэн бүтээгдэхүүн	239,093,856.74	250,996,803.11
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	876,972,297.41	854,681,717.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	876,972,297.41	854,681,717.91
39200	Биет хөрөнгө	574,430,297.41	550,951,717.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	420,834,755.11	420,834,755.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-104,170,723.10	-125,144,882.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,082,683,638.74	1,006,357,757.54
39204	Хуримтлагдсан элэгдэл	-888,179,331.31	-792,683,181.42
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	493,135,822.28	446,698,761.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-433,633,719.38	-408,484,221.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,661,276.24	27,661,276.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,346,557.54	-24,733,683.39
39214	Бусад үндсэн хөрөнгө	460,485.90	460,485.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	-15,349.53	-15,349.53
39300	Биет бус хөрөнгө	302,542,000.00	303,730,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	304,942,336.00	306,130,336.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,400,336.00	-2,400,336.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,751,110,674.73	1,808,493,066.29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	333,561,931.45	14,837,419.09
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,414,046.45	14,837,419.09
41300	Өглөг	8,414,046.45	14,837,419.09
41360	Бусад өглөг	8,414,046.45	14,837,419.09
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	8,414,046.45	14,837,419.09
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	325,147,885.00	0
42200	Урт хугацаат зээл	325,147,885.00	0
42220	Гадаад валют	325,147,885.00	0
42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	325,147,885.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,417,548,743.28	1,793,655,647.20
51	Засгийн газрын хувь оролцоо	1,417,548,743.28	1,793,655,647.20
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	507,379,700.00	832,527,585.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	302,542,000.00	302,542,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	271,453,530.23	322,412,549.15
51210	Өмнөх үеийн үр дүн	225,048,124.52	271,453,530.23
51220	Тайлант үеийн үр дүн	46,405,405.71	50,959,018.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336,173,513.05	336,173,513.05

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,751,110,674.73	1,808,493,066.29
---	---------------------------------------------	------------------	------------------

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	151,871,767.30	506,002,879.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	151,871,767.30	506,002,879.60
120	Нийтлэг татварын бус орлого	151,871,767.30	506,002,879.60
120002	Хүүгийн орлого	736,392.51	2,082,964.37
120009	Бусад орлого	909,090.91	8,806,250.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	2,940,915,929.51	2,651,633,999.67
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	2,790,689,645.63	2,156,520,334.44
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	105,466,361.59	455,043,860.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,466,361.59	455,043,860.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,466,361.59	455,043,860.68
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,466,361.59	455,043,860.68
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	86,572,579.32	438,318,764.37
210813	Бусад зардал /ТӨҮГ/	18,893,782.27	11,062,983.31
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	0	5,662,113.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	46,405,405.71	50,959,018.92
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	46,405,405.71	50,959,018.92

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	225,048,124.52	1,371,143,337.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	225,048,124.52	1,371,143,337.57
Тайлант үеийн үр дүн	0	0	46,405,405.71	46,405,405.71
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	271,453,530.23	1,417,548,743.28
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	809,921,700.00	336,173,513.05	271,453,530.23	1,417,548,743.28

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	325,147,885.00	0	0	325,147,885.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,135,069,585.00	336,173,513.05	271,453,530.23	1,742,696,628.28
Тайлант үеийн үр дүн	0	0	50,959,018.92	50,959,018.92
2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,135,069,585.00	336,173,513.05	322,412,549.15	1,793,655,647.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Лөгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,229,372,951.31	2,677,029,148.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,229,372,951.31	2,677,029,148.37
120	Нийтлэг татварын бус орлого	3,229,372,951.31	2,677,029,148.37
120002	Хүүгийн орлого	736,392.51	2,082,964.37
120009	Бусад орлого	1,900,586,895.80	8,800,250.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,328,049,663.00	2,666,145,934.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,108,221,458.27	2,801,166,992.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,108,221,458.27	2,801,166,992.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,108,221,458.27	2,801,166,992.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	773,919,529.00	700,012,449.37
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	773,919,529.00	700,012,449.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,906,308.76	202,143,948.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	111,906,308.76	202,143,948.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,654,876.60	47,915,350.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	57,654,876.60	47,915,350.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,424,067,922.12	1,193,230,323.13
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	481,894,512.17	228,580,644.70
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	942,173,409.95	964,649,678.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	740,672,821.79	657,864,922.38
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	1,505,968.17	2,041,707.73
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	154,583,036.90	74,784,187.56
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	7,915,474.00	10,089,247.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	576,668,342.72	570,949,780.09
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	121,151,493.04	-124,137,844.51
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	85,269,909.09	65,543,239.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,269,909.09	65,543,239.80
2200	Дотоод эх үүсвэрээр	85,269,909.09	65,543,239.80

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,269,909.09	65,543,239.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-85,269,909.09	-65,543,239.80
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	35,881,583.95	-189,681,084.31
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	348,296,175.96	384,177,759.91
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	384,177,759.91	194,496,675.60

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	х/нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	а/Улсын чанартай авто замын засвар арчлалт	м/төг	417,924,000.0	650,000,000.0	723,767,000.0	(73,767,000.0)	111.3
	б/Орон нутгийн чанартай замын засвар арчлалт, бусад	м/төг	1,714,655,800.0	1,405,200,000.0	1,368,452,900.0	36,747,100.0	97.4
2	Нийт орлого	м/төг	2,271,906,200.0	2,408,836,000.0	2,662,523,214.0	(253,687,214.0)	110.5
Үүнээс	а/ Хайрга дайрганы орлого		4,817,400.0	12,636,000.0	17,793,000.0	(5,157,000.0)	140.8
	б/ Гэрээний орлого		134,509,000.0	341,000,000.0	552,510,314.0	(211,510,314.0)	162.0
3	Нийт зардал	м/төг	2,257,867,900.0	2,380,769,200.0	2,611,564,195.1	(230,794,995.1)	109.7
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	287,419,900.0	483,730,500.0	438,318,764.4	45,411,735.6	90.6
4	Татварын өмнөх ашиг/алдагдал/	м/төг	14,038,300.0	28,066,800.0	50,959,018.9	(22,892,218.9)	181.6
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	12,634,500.0	25,260,120.0	45,863,117.0	(20,602,997.0)	181.6
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м/төг	260,637,300.0	350,056,700.0	287,082,617.5	62,974,082.5	82.0
	а/Орлогын татвар	м/төг	1,403,800.0	2,806,680.0	-	2,806,680.0	-
	б/НӨАТ	м/төг	67,947,000.0	160,000.0	-	160,000.0	-
	в/НДШ	м/төг	134,529,800.0	127,979,000.0	202,143,948.0	(74,164,948.0)	158.0
	г/Хүн амын орлогын албан татвар	м/төг	47,448,300.0	52,000,000.0	74,784,187.6	(22,784,187.6)	143.8
	д/Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	м/төг	2,492,000.0	2,500,000.0	1,729,486.0	770,514.1	69.2
	ё/Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	м/төг	1,034,000.0	4,500,000.0	1,464,196.0	3,035,804.0	32.5
	ж/Бусад татвар	м/төг	265,100.0	271,000.0	-	271,000.0	-
7	Төрийн өмчийн ноогдол ашиг	м/төг	-	12,630,100.0	6,960,800.0	5,669,300.0	55.1
8	Нийт ажиллагсдын тоо	Хүн	55.0	57.0	40.0	17.0	70.2
9	Нийт цалингийн сан	м/төг	717,406,100.0	1,010,593,000.0	700,012,449.4	310,580,550.6	69.3
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	1,087,000.0	1,477,500.0	1458359.3	19,140.7	98.7
11	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	төг	0.9938	0.9883	1	0.0	99.2
12	Хөрөнгө оруулалт	м/төг	93,417,000.0	71,582,500.0	71,582,500.0	-	100.0
13	Нийт авлага	м/төг	99,685,000.0	250,866,500.0	508,317,869.7	(257,451,369.7)	202.6

	Үүнээс: найдваргүй	м/төг	1,650,200.0	1,650,200.0	1,650,200.0	-	100.0
14	Нийт өглөг	м/төг	403,147,900.0	345,147,900.0	14,837,419.1	330,310,480.9	4.3
	Богино хугацаат өглөг	м/төг	78,000,000.0	20,000,000.0	14,837,419.1	5,162,580.9	74.2
	Урт хугацаат өглөг	м/төг	32,514,885.0	325,147,885.0	-	325,147,885.0	-

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь “Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам болон төмөрбетон гүүр, хоолой зэрэг замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг хариуцаж, авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг байнга ханган ажиллах” гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж, хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, гарсан эвдрэл, гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
- Замын барилгын үйлдвэрлэл эрхэлж, тоног төхөөрөмж, машин механизмыг үр ашигтай ажиллуулах,
- Авто замын засвар, арчлалтын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан авто замын урт, тэдгээрийн дагуу байрлах шугаман албадын байршил, засвар, арчлалтын ажлын нэгж, норм норматив, төсвийн норм, үнэлгээ болон түрээсийн тоног төхөөрөмжийн машин цагийн норм үнэлгээг мөрдөж ажиллах,
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

Тус ТӨХК нь 2024 онд нийт 113 км олон улсын болон улсын чанартай авто зам, гүүрийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгэх гэрээг “Зам тээврийн хөгжлийн яам”-тай байгуулан ажилласнаас гадна Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Сүхбаатар, Цагааннуур сумд, Дулаанхаан тосгоны авто замын шинэчлэл болон зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант онд “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 гишүүний цалинд нийт 13,100.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2024 онд 5 удаа зохион байгуулж, 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хэлэлцэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон гүйцэтгэх захиралтай байгуулсан

гэрээний биелэлтийг дүгнэх, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 12-нд өөрчлөлт орсон,*
- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12-нд өөрчлөлт орсон гэх мэт.*

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 2016 онд боловсруулагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг НБББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2016 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт, өөрчлөлт орсон тул эдгээрт нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 57,382.4 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн нь байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	<i>/мянган төгрөгөөр/</i>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	384,177.80	194,496.70	(189,681.10)

Авлага	250,866.80	508,317.90	257,451.10
Бараа материал	239,093.80	250,996.80	11,903.00
Үндсэн хөрөнгө	876,972.30	854,681.70	(22,290.60)
Нийт хөрөнгийн дүн	1,751,110.70	1,808,493.10	57,382.40
Өр төлбөр	333,561.90	14,837.40	(318,724.50)
Эздийн өмч	1,417,548.70	1,793,655.70	376,107.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,751,110.70	1,808,493.10	57,382.40

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 189,681.1 мянган төгрөгөөр буурсан нь 2,677,029.2 мянган төгрөгийн орлого олж, 2,871,525.8 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл 257,451.1 мянган төгрөгөөр өссөн нь Зам тээврийн яамтай байгуулсан “Үерийн улмаас үүссэн гэнэтийн эвдрэлийг сэргээн засварлах” болон “Сүхбаатар-Алтанбулаг, Дархан-Сүхбаатар чиглэлийн автозамын өвлийн арчлалт ажил”-ын санхүүжилт орж ирээгүйгээс,
- Өр төлбөр данс 318,724.5 мянган төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоол болон Зам тээврийн яамнаас өгсөн чиглэлийг үндэслэн 2009 онд үүссэн 325,147.9 мянган төгрөгийн урт хугацаат зээлийг бууруулж, компанийн дүрмийн санг нэмэгдүүлснээс голлон шалтгаалсан байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 болон 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 785 дугаар тогтоолоор “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2,408,836.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,380,769.2 мянган төгрөгөөр, цэвэр ашгийг 28,066.8 мянган төгрөгөөр тус тус тогтоож, хөрөнгө оруулалтын 1 арга хэмжээнд нийт 71,852.5 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,662,523.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,611,564.2 мянган төгрөгийн зардал гарган, 50,959.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

2024 онд Зам тээврийн яамнаас улсын чанартай зам засвар арчлалтын санхүүжилтийн орлого 723,767.0 мянган төгрөг, орон нутгийн чанартай зам засвар

арчлалтын орлого 1,366,452.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 570,303.3 мянган төгрөг *Идэйрга бутлуур, гэрээгээр хийгдсэн бусад ажил үйлчилгээ* зэрэг нийт 2,662,523.1 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлжээ.

Нийт орлогын гүйцэтгэл 2,662,523.1 мянган төгрөг болж төлөвлөгөөг 253,687.2 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар давуулан биелүүлсэн нь орон нутгийн зам засварын гэрээт ажлын орлогоос голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,611,564.2 мянган төгрөг болж төлөвлөснөөс 230,794.9 мянган төгрөг буюу 9.7 хувиар хэтэрсэн нь орон нутгийн зам засварын ажлын гүйцэтгэл төлөвлөснөөс эрс нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь ТӨБЗГ-аас баталсан 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дараах 4 худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим сайтаар нээлттэй зарласан байна. Үүнд:

- 172,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Битум шингэн худалдан авах”,
- 402,750.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Шатахуун худалдан авах”,
- 71,582.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Асфальтны индүү худалдан авах”,
- 49,680.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Шатах, тослох материал худалдан авах” гэх мэт.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулж, гүйцэтгэгчтэй “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан ажилласан байна. Үүнд:

- “Битум /шингэн/ худалдан авах” нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж, 2 дахь тендер шалгаруулалтад Айрон конкрейт ХХК 165,000.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлж, шалгуур хангасан тул тус компанийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан,
- “Шатахуун худалдан авах”- ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтад 2 компани санал ирүүлснээс 386,522.6 мянган төгрөгийн буюу хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Шунхлай петролиум” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан,
- “Асфальтны индүү худалдан авах” харьцуулалтын аргын сонгон шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулж, 3 дахь тендер шалгаруулалтад Бэлхи илч ХХК 71,505.8 мянган төгрөгийн үнийн санал ирүүлж, шаардлага хангасан тул гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан,

- “Шатах, тослох материал худалдан авах”- харьцуулалтын аргын сонгон шалгаруулалтад Ник компани 23,469.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлж, шалгуур хангасан тул тус компанийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, тус тус худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь 2024 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,896,156.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **28,961.6** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хэвлэл захиалга хийгээгүй, сургалтыг цахимаар зохион байгуулж албан томилолтын зардлыг хэмнэсэн,
- Байгууллагын ойн үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулаагүй,

- Үйл ажиллагаанд ашиглаж буй, эзэмшилд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашиглаж байгаа,
- Өр төлбөрийг бууруулах арга хэмжээ авсан гэх мэт.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 45 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1.Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын нийт эмэгтэйчүүдэд 800.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч өгсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:15.1.5:төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 157 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 174 дүгээр *“Санхүүгийн тайланд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,841.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 20,393.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	500.0	1	500.0	100
Албан шаардлага	3	2,841.1	3	2,841.1	100
Зөвлөмж	3	20,393.9	3	20,393.9	100
Нийт дүн	7	23,735.0	7	23,735.0	100

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас шатахууны тооцоо болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үнэн зөв толилуулсан эсэхийг түүвэрлэн шалгасан учир дараагийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дараах **190,908.9** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2024 оны 290 дүгээр тогтоолоор актлагдсан 140,681.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 46,437.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж зэрэг нийт 187,118.2 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг данс, бүртгэлээс хасаагүй,
- Санхүүгийн тайланд 2400.0 мянган төгрөгийн хөрөнгө борлуулсны орлого, 1,390.7 мянган төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан гэх мэт.

Аудитаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөрчил²д зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Ажил үйлчилгээний орлогын тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Борлуулалтын орлого, НӨАТ-ын тайлан, тооцоог тулган, хянаж, баталгаажуулахгүй байгаа нь НӨАТ-ийн өр төлбөр үүсэх, татварын хяналт шалгалтаар хүү, алданги, торгууль ногдох эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д **“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”** гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: НӨАТ-ын тооцоог дахин хянаж, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо
Актлагдсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй	1	187,118.2			1	7,680.9	1	187,118.2				
Орлого дутуу тайлагнасан	1	2,400.0			1	3,059.1	1	2,400.0				
Авлага дутуу тайлагнасан	1	1,390.7			1	3,059.1	1	1,390.7				
Нийт дүн	3	190,908.9			3	190,908.9	3	190,908.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Борлуулалтын орлого, НӨАТ-ын тайлан, тооцоог тулган, хянаж, баталгаажуулаагүй	1	-										
Нийт дүн	1	-										

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

